



СҮХБААТАР ДҮҮРГИЙН  
5 ДУГААР ХОРООНЫ ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021. оны 07. сарын 06 өдөр

Дугаар 07/01

Улаанбаатар хот


Үнэлгээний тайлан дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалт, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 10 дахь заалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн хорооны Иргэдийн санал асуулгаар тогтоох нь:

1. Тус хорооны нутаг дэвсгэрт орших “Өгөөж-Чихэр боов” ХХК-ийн гурилан бүтээгдэхүүний төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг дэмжсүгэй.

2. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах, үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг буруулах, арилгах, урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах иргэдийн саналыг харгалзан үзэхийг уламжилсугай.

3. Хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгжтэй хорооны тохижилт, нийтийг хамарсан их цэвэрлэгээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг хорооны Засаг дарга /Д.Амаржаргал/ -д үүрэг болгосугай.



ДАРГА

Б.НАРАНБААТАР

4140105014



**СҮХБААТАР ДҮҮРГИЙН  
5 ДУГААР ХОРООНЫ ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 07/01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Саналын тэмдэглэлийг 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 15<sup>00</sup> цагт Иргэдийн нийтийн хурлын танхимд үйлдэв.

**ХУРАЛДСАН:**

Б.Наранбаатар, Д.Гансүх, М.Алтансүх, Т.Энжаргал /Тэргүүлэгчдийн 5-н гишүүнээс 4 нь ирж, ирц 80% байгаа тул хурлыг хүчинтэйд тооцов/

Хэлэлцэх асуудлыг хурлын дарга Б.Наранбаатар танилцуулж, хурлыг удирдав.

**ХЭЛЭЛЦСЭН:**

Тус хороонд орших “Өгөөж-Чихэр боов” ХХК-д Байгаль орчин, Аялал жуулчлалын яам-аар Байгаль орчинд нөлөөлөх төлөв байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх тухай.

Коронавируст /КОВИД-19/ цар тахал дэлхийн ихэнх улсад дэгдсэнтэй холбоотой Улсын Онцгой комиссын даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдалд шилжүүлсэн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу аливаа хурал цуглааныг хориглосон учраас иргэдээс санал авч саналыг нэгтгэх байдлаар шийдвэрлэлээ.

Хүний бөөгнөрөл үүсгэхгүйгээр иргэн тус бүртэй биечлэн уулзахыг хуулиар хориглоогүй тул “Өгөөж-Чихэр боов” ХХК-ийн гурилан бүтээгдэхүүний төсөлд тус хорооны иргэдээс байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн танилцуулга хийж, санал авлаа. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, ажилгүйдэл нэмэгдэхээс сэргийлэх болон татварын орлогыг тасалдуулахгүй байх санаа зорилгыг агуулсан болно.

Уулзалт хийхдээ эрүүл мэндийн хамгаалах хэрэгслийг зүүж, ЭМЯ-наас гаргасан зөвлөмжийн дагуу аюулгүй байдлыг сахисан болно.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн 23 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүрт нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно” гэж заасан байдаг. СБД-ийн 5-р хороо нь 1415 өрхтэй. Иргэдийн нийтийн хурлын хүчинтэй ирц 51 иргэнээр бүрдэх тул 75 иргэнтэй хэсгийн ахлагч нарын оролцоотойгоор халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж биечлэн уулзаж танилцуулга хийж санал хүсэлтийг нь авлаа.

4120500045

Санал авах ажилд СБД 5-р хорооны Хэсгийн ахлагчид А.Алтансүлд, З.Цэцэгсүрэн, Б.Туяа, Г.Гантуяа, .Уранцэцэг, А.Баяраа болон “Өгөөж-Чихэр боов” ХХК-ийн Хуульч Э.Нарантунгалаг нар оролцов.

Санал асуулга 2021 оны 05 дугаар сарын 15-21-ний өдрүүдэд үргэлжилсэн болно.

#### СОНССОН НЬ:

НИЙТ САНАЛ:84

ДЭМЖСЭН: 70

ТАТГАЛЗСАН: 9

ТҮДГЭЛЗСЭН: 5

ХАШААГ ЗАСАЖ САЙЖРУУЛАХ: 5

ТОХИЖИЛТ ХИЙХ: 8

ҮНЭР ТАНАР ХИНШҮҮ ИХ: 7

ӨРГӨТГӨЛ БАРИУЛАХГҮЙ: 6

ЯВГАН ГАРЦ ХИЙХ: 5

Иргэн У.Баяндорж: Өгөөж үйлдвэрийн хашаан дотор төмрийн хог овоолдог, гадаадаас авсан түүхий эд нь стандартын бус байдаг. Нүхэн зорь, тохижилт хийх шаардлагатай. Савласан боов, боорцогон дотор удсан, хатуу боов боорцог цөөн цөөнөөр байдаг.

Иргэн М.Дөлгөөн: Тосны хиншүү их үнэртдэг ба хойд талыг тохижуулах хэрэгтэй.

Иргэн Наранцэцэг: Одоо байгаа байрлалыг өөрчлөхгүй байх, өндөр байшин бариулахгүй байх хэрэгтэй.

Иргэн С.Оюун-Эрдэнэ: Байршлаа өөрчлөхгүй байх, 20-р байрнаас дулаан авахыг зөвшөөрөхгүй.

Иргэн Д.Гансүх: Үнэр танар, хиншүү ихтэй, түгжрэл их үүсгэдэг.

Иргэн Б.Оюун Үнэр хиншүү ихтэй байдаг. Явган хүний гарц хийх хэрэгтэй.

Иргэн Б.Батцэнгэл: Оройн цагаар хурц гэрэл гаргадаг. Үйлдвэр өргөтгөхгүй байх хэрэгтэй.

Иргэн Д.Банди: Явган замын гарцтай болгох. Хүүхэд, хөгшид зам гарахад хэцүү байна.

Иргэн Э.Содтуяа: Хотын төвд орон сууцны дунд үйлдвэр байх нь хүндрэлтэй байна.

#### САНАЛЫГ НЭГТГЭЖ ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор танхимд цугларч бус хорооны иргэдтэй ганцаарчлан уулзаж танилцуулга явуулсаны эцэст тэдгээр 84 иргэдийн дотроос үйлдвэрлэл явуулахын эсрэг ямар нэгэн санал хүсэлт гаргаагүй бөгөөд тус үйлдвэрийн хойд хэсгээр тохижилт хийх болон үйлдвэрийн хашааны өнгө үзэмжийг засаж сайжруулах санал ирсэн.

“Өгөөж-Чихэр боов” ХХК-ийн гурилан бүтээгдэхүүний төсөлд байгаль орчны нөлөөллийн тайлантай танилцаж цаашид уг үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулахыг дэмжсэн санал байна.

Хорооны иргэдийн Нийтийн саналын нэгтгэлийг 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 16 цаг 10 минутад дуусгав.

ХЯНАСАН:

ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ИРГЭНИЙ НИЙТИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧИГ



Б.НАРАНБААТАР

З.ӨНӨР-ӨЛЗИЙ